



**ХОВД АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС**

**ХОВД АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**



ХОВД ХОТ 2021

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠬᠡᠯᠲᠡᠰ
ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠡᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ
ᠪᠠᠶᠳᠠᠯ
ᠬᠣᠪᠳᠠ ᠬᠣᠲ 2021

Гарчиг	
Хүн ам	3
Эрүүл мэнд	5
Бүртгэлтэй ажилгүй иргэд	7
Аж үйлдвэр	9
Нийгмийн даатгал	12
Халамж	14
Гэмт хэрэг	17
Үнэ	21
Цаг уур	24
Гадаадын харьяат	26
Том малын зүй бус хорогдол	27



ХҮН АМ, 2020 оны эхний 2 сард, өмнөх оны мөн үеэс

ᠬᠤᠨ
ᠠᠮ



Төрсөн хүүхэд
335
↓ 1.5 %
буурсан




Хүн ам :




Ховд аймгийн хэмжээнд 2021 оны 2 дугаар сарын байдлаар 330 эх амаржиж, 335 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 9 өөр буюу 2.7 хувиар, төрсөн хүүхэд 5 буюу 1.5 хувиар тус тус буурсан байна.

График 1. Төрөлт, 2 сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт, нас баралт өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

График 2. Нас баралт, 2 сарын байдлаар





ЭРҮҮЛ МЭНД, 2021 оны эхний 2 сард

МОНГОЛ
УЛС

Эмнэлэгт
хэвтэн
эмчлүүлэгчид



2020 I-II 4 518

2021 I-II 3 848

14.8% ↓



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2020 I-II 98

2021 I-II 59

39.8% ↓



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 I-II 11.7

2021 I-II 8.9 23.9% ↓

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 I-II 17.6

2021 I-II 8.9 49.4% ↓

Эрүүл мэнд :


Үзүүлэлт		2020 оны 2 сар	2021 оны 2 сар	<u>2021</u> <u>2020</u>
Нийт халдварт өвчин		98	59	60.2
Амьсгалын замын халдвар	Сүрьеэ	13	3	23.1
	Улаан эсэргэнэ	1	-	0.0
	Менингококк	-	-	-
	Гахайн хавдар	-	1	-
	Салхин цэцэг	10	2	20.0
	Гар хөл амны өвчин	2	-	0.0
	Нийт	26	6	23.1
Вируст гепатит		5	-	0.0
Зоонозын болон мал амьтнаас хүн халдварладаг өвчин	Тарваган тахал	-	-	-
	Бруцеллэз	-	-	-
	Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар	-	-	-
	Хачигт рикеттиоз	-	-	-
	Нийт	-	-	-
Ёлом		2	3	150.0
Бэлгийн замаар дамжих халдвар	Тэмбүү	23	23	100.0
	Гонококкт халдвар	8	9	112.5
	Трихомониаз	23	8	34.8
	Нийт	54	40	74.1
Арьсны мөөгөнцөртөх өвчин		11	10	90.9
Бусад		-	-	-

Халдварт өвчин өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчлөл буурсан боловч гонококкт халдвар 12.5 хувиар өссөн байна.




БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2021 оны 2 дугаар сарын эцэст

ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯᠲᠡᠢ ᠠᠵᠢᠯᠢᠭᠦᠢ ᠶᠢᠷᠭᠡᠳᠦ



Насны бүлгээр



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, 2021 оны эхний 2 сард



90

Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд



Ажил

11

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн

Бүртгэлтэй ажилгүй иргэд :


Бүртгэлтэй ажилгүй иргэд сарын эхэнд 786 байсан бол сарын эцэст 876 болж өссөн байна. 2 сард шинээр 90 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 11 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 69.9 хувь нь 15-34 насны залуучууд эзлэж байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.0 хувь нь бүрэн дунд боловсролтой, 19.5 хувь нь дипломын болон бакалаврын боловсролтой иргэд байна.

График 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд боловсролын түвшин хүйсээр, 2020/02 сар



График 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, хүйсээр, 2020/02 сар







АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2021* оны эхний 2 сард

ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠳᠡᠨ ᠤᠯᠤᠰ ᠶᠡᠬᠡ ᠶᠡᠬᠡᠳᠡᠨ ᠪᠦᠲᠡᠭᠦᠳᠡᠬᠦᠨ ᠨᠢᠶᠢ ᠶᠡᠬᠡᠳᠡᠷᠯᠡᠯ


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл

Д/д	Салбараар	Нийт бүтээгдэхүүн (оны үнээр, сая.төг)						2021	2021
		2020			2021			2020	2020
		I	II	I-II	I	II	I-II	II	I-II
A	1	2	3	4	5	6	7=5/2*100	8=6/3*100	
1	НИЙТ ДҮН	10423.6	8604.7	19028.0	1911.9	1945.6	3857.5	22.6	20.3
2	УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	9340.9	7557.8	16898.7	490.3	673.6	1163.9	8.9	6.9
3	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	9340.9	7557.8	16898.7	490.3	673.6	1163.9	8.9	6.9
4	БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	161.0	224.4	385.2	199.2	154.0	353.2	68.6	91.7
5	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	128.5	197.5	325.9	177.3	134.7	312.0	68.2	95.7
6	Мах боловсруулах, консервлох	99.4	120.5	219.9	88.4	90.2	178.6	74.9	81.2
7	Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.9	0.0	1.9	0.0	0.0	0.0		0.0
8	Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	27.2	77.0	104.1	88.9	44.5	133.4	57.8	128.1
9	Ундаа үйлдвэрлэл	10.3	7.6	17.9	6.7	3.3	10.0	43.4	55.9
10	Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	3.4	3.1	6.5	2.2	13.2	15.4	425.8	236.9
11	Хувцас үйлдвэрлэл	1.5	3.1	4.6	5.2	2.5	7.7	80.6	167.4
12	Кокс болон газрын түүхийг тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16.8	12.6	29.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
13	Тавилга үйлдвэрлэл	0.5	0.5	0.9	7.8	0.3	8.1	60.0	900.0
14	ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	824.9	724.2	1549.0	1145.3	1042.4	2187.7	143.9	141.2
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	824.9	724.2	1549.0	1145.3	1042.4	2187.7	143.9	141.2
16	УС ХАНГАМЖ; БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	96.8	98.3	195.1	77.1	75.6	152.7	76.9	78.3
17	Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	67.7	67.9	135.6	71.4	71.6	143.0	105.4	105.5
18	Хог хаягдлыг пуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	29.1	30.4	59.5	5.7	4.0	9.7	13.2	16.3

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 2 сарын байдлаар 3.9 тэрбум төгрөг болсон байна. Covid-19 цар тахал өвчин гарсаны улмаас аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 15.2 (79.7%) тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа нь уул уурхай олборлох салбарын үйлдвэрлэл 14 дахин буурсан нь голлон

нөлөөлсөн байна. Харин цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 0.6 (41.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 29.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (5.1%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2.0 (7.0%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, бохир ус зайлуулалт, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны үйлдвэрийн салбарын борлуулалт 0.05 (24.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл

Салбар	Нийт борлуулалт (сая.төг)						2021	2021
	2020			2021			2020	2020
	I	II	I-II	I	II	I-II	II	I-II
A	1	2	3	4	5	6	7=5/2*100	8=6/3*100
1 НИЙТ ДҮН	27394.4	3562.4	30956.8	10274.4	19101.4	29375.8	536.2	94.9
2 УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	26323.0	2525.2	28848.2	8937.9	17888.3	26826.2	708.4	93.0
3 Чулуун, хүрэн нүүрс олборлолт	26323.0	2525.2	28848.2	8937.9	17888.3	26826.2	708.4	93.0
4 БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	148.4	214.2	362.6	200.6	165.3	365.9	77.2	100.9
5 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	128.5	197.5	326.0	177.3	134.7	312.0	68.2	95.7
6 Мах боловсруулах, консервлох	99.4	120.5	219.9	88.4	90.2	178.6	74.9	81.2
7 Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1.9		1.9	0.0	0.0	0.0		0.0
8 Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	27.2	77.0	104.2	88.9	44.5	133.4	57.8	128.0
9 Ундаа үйлдвэрлэл	10.3	7.6	17.9	6.7	3.3	10.0	43.4	55.9
10 Ээрэх, нэхэх, давуун материал бэлтгэх үйлдвэрлэл	4.9	6.2	11.1	3.2	1.1	4.3	17.7	38.7
11 Хувцас үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	4.2	14.7	18.9		
12 Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.2	2.5	6.7	0.5	0.3	0.8	12.0	11.9
13 Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	8.4	11.2	19.6		
14 Тавилга үйлдвэрлэл	0.5	0.4	0.9	0.3	0.0	0.3	0.0	33.3
15 ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	824.9	724.2	1549.1	1061.9	973.5	2035.4	134.4	131.4
16 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	824.9	724.2	1549.1	1061.9	973.5	2035.4	134.4	131.4
17 УС ХАНГАМЖ; БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	98.1	98.8	196.9	74.0	74.3	148.3	75.2	75.3
18 Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	67.7	67.9	135.6	71.4	71.6	143.0	105.4	105.5
19 Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	30.4	30.9	61.3	2.6	2.7	5.3	8.7	8.6

Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, сая төгрөг

Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний 2 сарын байдлаар 12.1 мянган хүнд 9.4 тэрбум төгрөгний тэтгэвэр олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчдын тоо 51 (0.4%) хүнээр, олгосон тэтгэвэр 0.9 (11.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Монгол Улсын Засгийн газраас Коронавирус халдвар (COVID-19) цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа төрийн бус өмчийн аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургуульд ажиллаж байгаа даатгуулагчдад 2020 оны 7 дугаар сараас эхлэн сар бүр 200.0 мянган төгрөгийн дэмжлэгийг олгож байна

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, олгосон тэтгэвэр

Д.д	Сумын нэрс	2020- II		2021-II он		2021/2020%	
		Тэтгэвэр авагчдын тоо	Олгосон тэтгэвэр сая.төг	Тэтгэвэр авагчдын тоо	Олгосон тэтгэвэр сая.төг	Тэтгэвэр авагчдын өсөлт бууралтын хувь	Олгосон тэтгэвэрийн өсөлт бууралтын хувь
1	Алтай	436	304.0	454	343.5	104.1	113.0
2	Булган	1452	687.5	1468	727.1	101.1	105.8
3	Буянт	400	289.3	417	328.8	104.3	113.7
4	Дарви	380	281.4	396	321.0	104.2	114.1
5	Дөргөн	382	279.6	396	319.1	103.7	114.2
6	Дуут	265	238.3	280	277.9	105.7	116.6
7	Зэрэг	426	300.5	447	340.1	104.9	113.2
8	Манхан	504	326.6	521	366.1	103.4	112.1
9	Мөст	436	305.4	455	345.0	104.4	113.0
10	Мөнххайрхан	285	247.9	305	287.5	107.0	116.0
11	Мянгад	519	324.5	529	364.1	101.9	112.2
12	Үенч	584	366.2	603	405.7	103.3	110.8
13	Ховд	376	281.3	388	320.8	103.2	114.1
14	Цэцэг	311	253.7	328	293.2	105.5	115.6
15	Чандмань	395	289.8	412	329.3	104.3	113.7
16	Эрдэнэбүрэн	399	288.2	419	327.7	105.0	113.7
17	Жаргалант	4254	3,366.5	4277	3669.3	100.5	109.0
	Дүн	12044	8,430.6	12095	9,366.4	100.4	111.1

Тэтгэмжийн даатгалын сангаас 503 хүнд 0.5 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 85 (20.3%) хүнээр өсч, олгосон тэтгэмжийн н хэмжээ 18.3 (3.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авагчдын тоо, олгосон тэтгэмж

Д.д	Сумын нэрс	2020-II		2021-II		2020/2021%	
		Тэтгэмж авагчдын тоо	Олгосон тэтгэмж сая.төг	Тэтгэмж авагчдын тоо	Олгосон тэтгэмж сая.төг	Тэтгэмж авагчдын өсөлт буурал тын хувь	Олгосон тэтгэмжийн өсөлт буурал тын хувь
1	Алтай	13	12.7	19	19.6	146.2	154.3
2	Булган	34	29.7	26	29.1	76.5	98.0
3	Буянт	15	16.5	14	13.6	93.3	82.4
4	Дарви	12	9.7	15	11.2	125.0	115.1
5	Дөргөн	11	9.5	16	11.2	145.5	118.1
6	Дуут	11	8.9	11	8.5	100.0	95.5
7	Зэрэг	12	10.9	13	10.6	108.3	97.2
8	Манхан	13	12.6	22	20.0	169.2	158.7
9	Мөнххайрхан	11	9.0	12	9.5	109.1	105.6
10	Мөст	10	8.7	23	11.7	230.0	134.5
11	Мянгад	11	10.2	15	13.8	136.4	134.8
12	Үенч	10	8.9	14	11.5	140.0	129.2
13	Ховд	12	10.7	16	14.1	133.3	131.7
14	Цэцэг	13	9.8	14	9.8	107.7	100.0
15	Чандмань	10	9.2	15	12.7	150.0	137.8
16	Эрдэнэбүрэн	11	9.4	12	9.3	109.1	98.9
17	Жаргалант	209	295.7	246	284.3	117.7	96.1
	Дүн	418	482.1	503	500.4	120.3	103.8

ХАЛАМЖ :

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 2 сарын байдлаар 13.3 мянган хүнд 2.0 тэрбум төгрөгний тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 18.6 (58.4%) мянган хүнээр, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 1.0 (34.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 288.0 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100.0 мянган төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай хүүхдэд 16.0 мянган төгрөг, насанд хүрэгчдэд 32.0 мөнгөн төгрөгийг тус тус олгохоор шийдвэрлэсэн юм.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт эхний сарын байдлаар 1.5 мянган хүн хамрагдсан нь өмнөх оноос 7 (0.4%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 0.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 0.4 (60.9%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 75.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 22.9 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 1.3 хувь нь ахмад настан, 0.5 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний 2 сард 1.9 мянган хүн хамрагдсаны 62.7 хувь нь ахмад настныг асарч байгаа иргэн, 34.4 хувь нь байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаа, 2.1 хувь нь бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж байгаа, 0.8 хувь нь хамгаалалт шаардлагатай болосон хүүхдийг болон ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрамжилж байгаа иргэн байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны 1 сард 0.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 0.04 (35.3%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

4.6 мянган эхэд 224.0 сая төгрөгийн цалинтай ээж хөтөлбөрийн мөнгө, 3.8 мянган өрхөд 218.1 сая төгрөгийн хүнс тэжээлийн тусламжийн мөнгийг олгожээ.

Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт

	2020-II		2021-II		2021/2020	
	Хүний тоо	Олгосон тэтгэмж /сая.төг/	Хүний тоо	Олгосон тэтгэмж /сая.төг/	Хүний тоо	Олгосон тэтгэмж
Халамжийн сангийн орлого бүгд		3288.9	0.0	1984.9		60.4
Улсын төсвөөс		3288.9		1959.9		59.6
Орон нутгийн төсвөөс		0		25.0		
Халамжийн сангийн зарцуулалт бүгд	31881	3003.6	13251	1977.7	41.6	65.8
Улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламж	31870	2990.4	13243	1968.1	41.6	65.8
Халамжийн тэтгэвэр	1573	574.7	1580	924.7	100.4	160.9
Ахмад настны тэтгэвэр	22	7.9	21	12.1	95.5	153.2
Хөдөлмөрийн чадвараа алдсан ХБИ	1188	421.5	1190	688.8	100.2	163.4
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	7	2.5	8	5.2	114.3	208.0
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	356	142.8	361	218.6	101.4	153.1
Халамжийн тэтгэмж	1668	256.5	1866	318.0	111.9	124.0
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	1025	152.2	1170	194.3	114.1	127.7
Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаагийн улмаас ХЭХНИ	587	95.7	642	114.7	109.4	119.9
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан, асран хамгаалж байгаа иргэнд олгох	38	5.8	39	6.5	102.6	112.1
Хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд	16	2.5	14	2.4	87.5	96.0
Ганц бие ахмад настан ХБИ-ийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	2	0.3	1	0.08	50.0	28.0
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	28629	2159.2	9797	725.4	34.2	33.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох	289	100.9	291	166.0	100.7	164.5
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	0	0.0	52	3.1	-	-
Жирэмсэн эхийн тэтгэмж	1119	34.3	846	67.8	75.6	197.7
ХБИ-д үзүүлэх тусламж	483	59.1	77	12.6	15.9	21.3
Хүнс тэжээлийн тусламж	9086	194.9	3830	218.1	42.2	111.9
Алдарт эхийн одонгийн тусламж	8599	1140.6	0	0.0	-	-
Алдар шолгой ахмадуудад үзүүлсэн	51	18.2	0	0.0	0.0	0.0
Насны хишиг	3335	276.8	0	0.0	-	-
Цалинтай ээж хөтөлбөр	4290	208.4	4588	224.0	106.9	107.5
Өрх толгойлсон эцэг эх хөтөлбөр	0	0.0	8	3.3	-	-
2 ихэр хүүхэд төрүүлж өсгөж байгаа өрх, иргэнд олгох	1	2.0	1	2.0	100.0	100.0
4 хүртэлх насны 3 ба түүнээс дээш ихэр хүүхэдтэй өрх, иргэнд			0	0.0		
Ахмад настуудад үзүүлэх хөнгөлөлт	1376	124.0	104	28.5	7.6	23.0
Орон нутгийн халамжийн сангийн зарцуулалт бүгд	11	13.2	8	9.6	72.7	72.7
Нийгмийн халамжийн сан	11	13.2	8	9.6	72.7	72.7
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	4	4.8	0	0.0	0.0	0.0
Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрх	2	2.4	8	9.6	400.0	400.0
Амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх	0	0.0	0	0.0	-	-
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	5	6.0	0	0.0	0.0	0.0
ОНОТХУй.лчл.гээний зардал	0	0.0	0	0.0	-	-

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжинд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас доторхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ,

ᠮᠤᠩᠭᠡᠯᠤ
ᠰᠤᠷᠭᠡᠨ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

111

85

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

69



Гэмтсэн хүн

24



Нас барсан хүн

2

Гэмт хэрэг үйлдсэн



55

55

Гэмт хэрэг

Энэ оны эхний 02 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 85 болж өнгөрсөн оны мөн үеэс 26 (23,4 %) -аар буурчээ. Гэмт хэргийн улмаас 24 хүн гэмтэж, 69 иргэн хохирсон байна.

Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 17,6%, хулгайлах гэмт хэрэг 10,0%, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22,2% хувиар тус тус өсч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 30,0%, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 80,0%, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 75,0%, мал хулгайлах гэмт хэрэг 61,1%, залилах гэмт хэрэг 16,6 хувиар тус тус буурчээ.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 4, согтуугаар үйлдэгдсэн 17, гудамж талбайд 8, гэр орон сууцанд 27, бүлэглэн үйлдсэн 4 гэмт хэрэг бүртгэгджээ.

Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 55 байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл эмэгтэй хүн оролцсон 2 хэрэг гарсан байна. Гэмт хэргийн улмаас 106.1 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 137.8 сая (56.4%) сая төгрөгөөр буурч, иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 28.4 сая төгрөг буюу 26.8 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 8.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

ХОВД АЙМГИЙН НУТАГ ДЭВСЭРТ 2020 ОНЫ ЭХНИЙ 01 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Асуулт		2020 оны эхний 2 сар	2021 оны эхний 2 сар	Өсөлт бууралт хувиар
	Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл	519	600	15.6%
Үүнээс	Гэмт хэргийн шинжтэй	156	179	14.7%
	Зөрчлийн шинжтэй	363	421	15.9%
	Бүртгэгдсэн гэмт хэрэг	111	85	-23.4%
	Илрээгүй хэрэг	63	37	-41.2%
	Илрүүлэлтийн хувь	24.1%	2.6%	-21.5
	Согтуугаар үйлдэгдсэн	21	17	-19.0%
	Бүлэглэн үйлдэгдсэн	8	4	-50.0%
	Эмэгтэй хүн оролцсон	4	2	-50.0%
	Гэр бүл хүчирхийллийн улмаас	2	4	100.0%
	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	5	1	-80.0%
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг	18	22	22.2%
	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах		2	
	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	17	20	17.6%
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	60	42	-30.0%
Үүнээс	Хулгайлах гэмт хэрэг	10	11	10.0%
	Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг	10	10	
	Залилах гэмт хэрэг	18	15	-16.6%
	Хөрөнгө завших гэмт хэрэг	6	5	-16.6%
	Мал хулгайлах гэмт хэрэг	18	7	-61.1%
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	10	3	-70.0%
	Эдийн засгийн гэмт хэрэг		1	
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	6	6 дахин
	Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг	1	2	100.0%

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно. 16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно. Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Авлигын гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.

ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 2 дүгээр сард Ховд аймгийн хэмжээнд өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 2 дүгээр сард өмнөх оны мөн үеэс хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 2.2 хувь, гэр ахуйн тавилга бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч хувийн тээвэр, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний бүлгийн үнэ 6.8 хувиар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 2 дүгээр сард өмнөх сараас хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ 0.2 хувиар дүнгээрээ өссөн байна. Харин тээврийн үйлчилгээний үнэ 0.2 хувиар буурсан бусад үзүүлэлтүүдэд өөрчлөлт ороогүй үнэ хэвийн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2021 оны 02 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2021 II	2021 II
	2020 II	2021 I
Ерөнхий индекс	101.9	100.4
Хүнсний бараа, ундаа ус	106.4	101.3
Согтууруулах ундаа,тамхи	100.9	100.3
Хувцас, бөс бараа, гутал	101.7	100.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	105.9	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	101.1	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	101.3	100.0
Тээвэр	93.2	99.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	102.2	100.3

Гол нэр төрлийн барааны үнэ

НЭР ТӨРӨЛ	2020 оны 2 сар	2021 оны 2 сар	Харьцуулсан хувь
Гурил, 1-р зэрэг /алтантариа/	1500	1650	110
Гурил, 2-р зэрэг /алтантариа/	1200	1400	116.6
Гоймон, гадаад	1800	1800	100
Талх, орон нутгийн үйлдвэрийн, ш	1100	1200	109.1
Гурилан боорцог, 0.5 кг	2400	2500	104.2
Цагаан будаа, задгай, кг	2400	2500	104.2
Хонины мах, ясгүй	9000	10000	111.1
Үхрийн мах, ясгүй	11000	12000	109.1
Ямааны мах, ясгүй	7000	8000	114.3
Сүү, задгай, литр	2500	2500	100
Сүү, савласан, 1л	2900	3200	110.3
Ургамлын тос, 1л	4500	5500	122.2
Өөхөн тос, кг	1500	1500	100
Шар тос, кг	20000	20000	100
Масло задгай, 1кг	4000	4500	112.5
Төмс, кг	600	800	133.3
Лууван, кг	1000	800	80
Манжин, кг	3000	1000	33.3
Байцаа, кг	2500	2000	80
Сонгино, кг	2500	2500	100
Элсэн чихэр, кг	2500	2500	100
Хатуу чихэр, 1кг	6500	7000	107.7
Янжууртамхи West	3000	3000	100
Янжууртамхи "Улааншонхор"	2500	2500	100
Түлшний мод, шуудайгаар	6000	5000	83.3
Эдийн саван, ок	800	900	112.5
Бензин, А-80, 1литр	2010	1550	77.1
Бензин, А-92, 1 литр	2090	1650	78.9
Дизелийн түлш, 1литр	2400	1800	75

ЦАГ УУРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		28/02/2021										
Д.д	Сумын нэрс	Агаарын температур			Хөрсний температур			Салхи Хамгийн их хурд	Хур тунадас		Цас	
		Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага		Хур тунадас /мм/	цасны зузаан	цасны бүрхэл/ба тн/	нягт
1	Алтай сум	-9.3	6	-24	-11	9	-30	6	11.7	14	10	0.14
2	Булган сум	-10.6	8	-28	-10	16	-33	14	4.4	1	10	
4	Дарви сум	-5.9	15	-25				22	1.4	1		
5	Дөргөн сум	-7.3	13	-21	-7		-25	20				
6	Дуут	-8.4	7	-24				24				
7	Зэрэг сум	-6.9	15	-20	-7	18	-30	32				
8	Манхан сум	-6.2	15	-24	-6	24	-26	24				
9	Мөнххайрхан сум	-7	10	-22	-7	15	-26	23	0.2			
10	Мөст сум	-7.7	8	-21	-8	16	-28	21				
11	Мянгад сум	-7.6	14	-21				14				
12	Үенч сум	-9.4	6	-23				12	2.3	4		
13	Ховд сум	-6.5	11	-22	-6	23	-25	29				
14	Цэцэг сум	-12	11	-33	-11	24	-37	18				
15	Чандмань сум	-5.7	13	-19	-5	23	-24	25				
16	Эрдэнэбүрэн сум	-7.5	12		-7			22				
17	Жаргалант	-6.7	13	-23	-7	21	-27	24				
	Дүн	-7.8	15	-33	-7.67	24	-37	32	20			

2021 оны 2-р сарын цаг агаарын ерөнхий тойм

2021 оны 2-р сард Ховд аймгийн нийт нутгаар агаарын дундаж температур -7.8 хэм хүйтэн, хамгийн дулаан нь Дарви, Манхан, Зэрэг сумдад 15 хэм дулаан, хамгийн хүйтэн нь Цэцэг суманд -33 хэм, хөрсөндөө нийт нутгаар 24-37 хэм хүрч хүйтэрсэн байна. Салхи шуурганы хувьд: Энэ сард ихэнх нутаг цасгүй, нэлээд салхи шуургатай байсан төдийгүй салхины хурд 12-32 м/с хүрч шороон шуурга шуурч хүчтэй салхилсан байна. Салхины хамгийн их хурд Зэрэг суманд 32 м/с, Ховд суманд 29м/с хүрч шороон шуурга шуурсан байна. Хур тунадасны хувьд: Энэ сард нутгийн өмнөд хэсгээрээ 2.3-11.7 мм тунадас орж, Алтай суманд 14 см, Булган сум 4.4 см, Үенч суманд 2.3 см зузаан цасан бүрхүүлтэй, Дарви болон Мөнххайрхан сумдад 0.2-1.4 мм хур тунадас орсон ба бусад нутгаар хур тунадас ороогүйн улмаас агаар дахь чийгийн хэмжээ бага, хуурайшилтай байна.

АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН АГУУЛАМЖ

Д.д	Үзүүлэлтүүд	Сарын дундаж /мг/м3/	Хамгийн их /мг/м3/	ХА-с давсан хувь	Хэмжилтийн тоо /хоногоор/	
1	2020	Хүхэрлэг хий- SO ₂	0.014	0.025	-	51
2	оны 02 сар	Азотын давхар исэл -NO ₂	0.046	0.078	-	51
3		Нүүрстөрөгчийн дутуу исэл -CO	1.77	5.05	-	51
4		Тоос PM 10	0.287	0.576	2.8-5.7	7
1	2021	Хүхэрлэг хий- SO ₂	0.029	0.046	-	57
2	оны 02 сар	Азотын давхар исэл -NO ₂	0.044	0.078	-	57
3		Нүүрстөрөгчийн дутуу исэл -CO	3.15	6.97	-	57
4		Тоос PM 10	-	-	-	-

УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораторит хийгдсэн агаарын чанарын хяналтын тооллогоор хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ хүлцэх агууламжаас даваагүй хэдий ч нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ өмнөх жилийн мөн үеийнхээс 1.4 мг-аар, хүхэрлэг хийн хэмжээ 0.03 мг-аар тус тус өссөн байна. Жич: Агаар дахь тоосны агууламжийг хэмжих багаж эвдэрсэн тул РМ10 -ийг хэмжихгүй байгаа болно.


ХОВД АЙМАГТ ОРШИН СУУЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД БА ГАДААДЫН ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2021.03.09		Ховд хот						
Ажлын үзүүлэлт	Үйлчилгээний төрөл	2020.11.01-2020.11.17	2020.11.17-2020.12.08	2020.12.09-2021.01.08	2021.01.08-2021.02.08	2021.02.09-2021.03.08	Нийт	
Виз олголт	Орох	0	0	0	0	0	0	
	Гарах-орох	0	0	0	0	0	0	
	Дамжин өнгөрөх	0	0	0	0	0	0	
	Нийт	0	0	0	0	0	0	
Бүртгэл, хасалт	Түр ирэгч	Бүртгэл	0	0	0	0	0	0
		Хасалт	0	0	0	0	0	0
	ОСЗ /хасалт/	0	0	8	6	0	14	
	Нийт	0	0	8	6	0	14	
Хяналт, шалгалт	Төлөвлөгөөт	0	0	2	2	1	5	
	Төлөвлөгөөт бус	0	0	0	0	0	0	
	Зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол	Амаар	0	0	0	0	0	0
		Бичгээр	0	0	1	0	0	1
Бусад	Оршин суугаа	12	12	9	9	9	9	
	гадаадын иргэд	1	1	1	3	3	3	
	Нийт иргэд	65	65	62	54	57	57	




ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2020/02



2021/02



Том малын зүй бус хорогдлын мэдээ

2021 оны 2-р сарын байдлаар аймгийн хэмжээнд 3.0 мян.толгой мал зүй бусаар хорогджээ. Урьд оны мөн үетэй харьцуулахад хорогдол 2.3 мянгаар буурчээ. Том малын зүй бус хорогдлын мэдээг сумаар үзэхэд Цэцэг сум /263/, Эрдэнэбүрэн сум /379/, Ховд сум /273/, Үенч сум /212/ мал хорогдож, хамгийн их мал хорогдсон сумын тоонд орж байна.

Том малын зүй бус хорогдлын мэдээ

№	сум	2020/2	2021/2	зөрүү	Үүнээс				
					Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Жаргалант сум	8	63	55	4	11		15	33
2	Алтай сум	1510	164	-1346	7			64	93
3	Булган сум	1003	185	-818	10	6		70	99
4	Буянт сум	54	143	89	15			80	48
5	Дарви сум	205	132	-73	13			101	18
6	Дөргөн сум	156	74	-82	14			5	55
7	Дуут сум	110	189	79	17	20		120	32
8	Зэрэг сум	120	166	46			20	110	36
9	Манхан сум	250	139	-111	5		18	95	21
10	Мөнххайрхан сум	180	129	-51	1	3		95	30
11	Мөст сум	251	129	-122				98	31
12	Мянгад сум	501	201	-300	16	23		130	32
13	Үенч сум	503	212	-291				156	56
14	Ховд сум	410	273	-137	13	22		157	81
15	Цэцэг сум	6	269	263			6	158	105
16	Чандмань сум	25	237	212	21	8		152	56
17	Эрдэнэбүрэн сум	110	379	269	23	14	2	230	110
	Дүн	5402	3084	-2318	159	107	46	1836	936